



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.01.26 № 01/200
танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА НАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ -ийн 6 дугаар зүйлд заасан нөхцөл хангасан даатгуулагчид жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоож олгохтой холбоотой дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн байгууллагаас цахимаар бичиж илгээсэн жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг даатгуулагч хүлээн авч, тэтгэмж авах хүсэлтээ баталгаажуулснаар тухайн даатгуулагчийн иргэний улсын бүртгэлийн хаягаар буюу харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт илгээгдэж байна. Иймд цахимаар баталгаажуулж ирүүлсэн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтийг шинэ системээс хуваарилагдсан Нийгмийн даатгалын газар нь тогтоож олгоно.

2. Харин даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цаасан хэлбэрээр бичиж олгосон тохиолдолд албан журмын даатгуулагчийн хувьд ажил олгогчийн харьяаллаар буюу тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн Нийгмийн даатгалын газраас тэтгэмжийг тогтоож олгож болно.

3. Жирэмсний тэтгэмжээ ажил олгогчийн харьяаллаар бодуулж авсан даатгуулагчийн амаржсаны эмнэлгийн хуудас нь даатгуулагчийн иргэний улсын бүртгэлийн хаягаар илгээгдсэн тохиолдолд даатгуулагчийн амаржсаны тэтгэмжийг шинэ системээс хуваарилагдсан Нийгмийн даатгалын газар нь тогтоож олгоно.

4. Даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг эмнэлгийн байгууллагаас цахим, эсхүл цаасаар бичиж иргэний улсын бүртгэлийн хаягаар илгээж байгаатай холбогдуулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын тэтгэмжийн даатгалын сангийн зардал нь тухайн улирлын батлагдсан төсвөөс хэтрэхээр бол төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналаа Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт ирүүлэх хэрэгтэй.

Иймд зөвлөмжийг байцаагч, ажилтнуудад танилцуулан мэдээллээр ханган, тэтгэмж олгох асуудлыг шуурхай шийдвэрлэж ажиллах нь зүйтэй.

ДАРГА


Я.МӨНХЗУЛ

My doc.BHSG A-4 /24.01/ sar

1524070269